



АУДИТЫН КОД: САГ-2018/13/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор Б.Ариунжаргал


Утас: 260512 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	6
3	Аудитын тайлан	8
3.1	Оршил.....	8
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	8
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	9
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
3.5	Дотоод аудит.....	10
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	12
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй, асуудал, гаргасан шийдэл	12
3.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар	12
3.9.2	Авлагын талаар	13
3.9.3	Бараа материалын талаар	13
3.9.4	Үндсэн хөрөнгийн талаар.....	13
3.9.5	Зардлын талаар	14
3.9.6	Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар	14
3.9.7	Дотоод аудитын талаар.....	15
3.9.8	Шилэн дансны талаар.....	15
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	15
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	15
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	16
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	16
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
3.16	Үр өгөөжийн тооцоолол	16
4	Менежментийн захидал.....	17
4.1	Мөнгөн хөрөнгийн талаар	18
4.2	Авлагын талаар	19
4.3	Бараа материалын талаар	20
4.4	Үндсэн хөрөнгийн талаар.....	21
4.5	Зардлын талаар	22
4.6	Нягтлан бодох бүртгэл, тайлагналийн талаар.....	23
4.7	Дотоод хяналтын талаар.....	24
4.8	Шилэн дансны талаар.....	25
5	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	26
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	26
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	27
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	28
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	29
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	30
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	31
6.1	Акт	35
6.2	Албан шаардлага.....	36



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тус байгууллагын мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, шилэн данс, үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 17-ноос 2018 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 04 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн



захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Ариунжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1/1305 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын 1926 оны 49 дүгээр хурлаас Шүүх яамны шүүх хэлтсийг татан буулгаж, түүний үүргийг Улсын Дээд шүүхэд шилжүүлэн, 1927 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр БНМАУ-ын Дээд шүүхийг анх байгуулжээ.

2013 онд шинээр батлагдсан "Монгол Улсын Шүүхийн тухай" хуулиар Монгол Улсын Шүүхийн тогтолцоо нь: Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэхээр заасан байна.

Энэ хуулиар Улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ гэж заасны дагуу Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Иргэний хэргийн танхимын тэргүүн, Захиргааны хэргийн танхим тэргүүн болон 21 шүүгч, нийт 25 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах ажиллагаа эрхлэн гүйцэтгэх болжээ.

Улсын Дээд шүүх нь дараах эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох;
- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг хамгаалах;
- Хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх;
- Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх.

Ерөнхий шүүгч дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.


Улсын Дээд шүүх тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Ерөнхий шүүгчийн эрхлэх хүрээний асуудлаар хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд болон шүүхээс хууль хэрэглэх асуудалд зарчмын өөрчлөлт, хүний эрх, эрх чөлөөг шүүхийн журмаар нөхөн сэргээх, баталгаажуулах зэрэг ажлыг төлөвлөж Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай гэх мэт хуулиудыг шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан байна.

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Шүүхийн Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг батлах тухай” 08 дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхийн бүтэц, орон тооны хязгаарыг баталсны дагуу 2017 оны жилийн эцсийн байдлаар Ерөнхий шүүгч 1, шүүгч 23, Шүүхийн Тамгын газарт 85, нийт 109 хүн ажиллаж байна.

Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын үйл ажиллагааны олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын



стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 26 горим, сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн санхүүгийн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын Дээд шүүхийн дотоод аудитын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад “дунд” байна гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Улсын Дээд шүүх нь Дотоод аудитын албатай бөгөөд Ерөнхий шүүгчийн 2017 оны 05 дугаар тогтоолоор тайлант онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 чиглэлээр хяналт хэрэгжүүлэхээр батлуулснаас удирдлагын үүрэг даалгаврын хэрэгжилт болон төсөв, санхүүгийн хяналт шалгалтын ажлууд хийгдээгүй байна. Энэ нь санхүүгийн дотоод хяналтыг сулруулах эрсдэлийг дагуулж байна.



**Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн
2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Хүснэгт №1

Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	10	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	8	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	8	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	2
		Дүн (сая.төг)	0.8
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	7
		Дүн (сая.төг)	0.8
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	0
		Дүн (сая.төг)	0

**Эх сурвалж: Улсын Дээд шүүхийн Дотоод аудитын албаны захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон зэргийн нэмэгдлүүдийг тооцон олгож буй байдалд хийсэн нийцлийн аудитын тайлан*

Дотоод аудитын албанаас 2017 онд Улсын Дээд шүүхийн захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон зэргийн нэмэгдлүүдийг тооцон олгож буй байдалд нийцлийн аудит хийсэн бөгөөд зарим ажилтнуудын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг зөв тооцоогүй илүү болон дутуу олгосон, цалингийн шатлал, ангилалыг зөрүүтэй тооцох зэрэг зөрчил дутагдал илэрч 7 зөвлөмж өгч ажиллажээ.

Ерөнхий шүүгчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 ажилтанд илүү, 1 ажилтанд дутуу олгосон нийт 0.7 сая төгрөгийн зөрчлийг 2018 оны Улсын дээд Шүүхийн Тамгын газрын даргын 2018 оны Б/28 дугаар тушаалаар арилгуулж ажилласан байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга


Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны урсгал зардалд зарцуулахаар 4,083.1 сая төгрөгийн төсөв батлуулснаас гүйцэтгэлээр 83.2 хувь буюу 3,395.6 сая төгрөгийг зарцуулж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн үлдэгдэл 687.6 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу 226 хуульч Улсын Дээд шүүхэд өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр төлсөн үйлчилгээний хөлс 6.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, Улсын Дээд шүүхийн шүүгчдийн 2013 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийн бүртгэлийн журам”-ын 6.3-т заасан зориулалтаар зарцуулж, үлдэгдэл 0.4 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дэлгэрэнгүйд тусгаж тайлангийн 5.5-д харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилтын хүрээнд shilendans.gov.mn цахим хуудасны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цонхнуудад дараах мэдээллийг байршуулж байх үүрэгтэй байна. Үүнд:



А. Төсөв/гүйцэтгэл цэсэнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр);
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр);
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр).

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаар шалгаж үзэхэд илэрсэн зөрчлийн талаар тайлангийн 3.9.8 хэсэгт тусгасан болно.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 чиглэлийн 29 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй, асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар


- Тайлант онд Улсын Дээд шүүхийн нэр дээрх Улаанбаатар хотын банкинд байрлах байгууллагын картын дансаар тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн тэтгэмжийн 118.1 сая, ажилчдад олгох цалингийн 19.0 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг дамжуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.5-д *"Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар захиалга хийхдээ ... төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн хязгаарыг дагаж мөрдөнө"* гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Бэлэн мөнгөний үлдэгдэлд сар бүр тооллого хийж, тооцоог бодон, үр дүнг баталгаажуулдаггүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн бор*



дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.2.4-т "мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал ... сар бүрийн 1-нээр" гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлэн мөнгөний үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоог бодож баталгаажуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

• Тайлант онд хувь хүмүүсээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний орлогоос 3.4 сая төгрөгийн татварыг суутгаж төсөвт шилжүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараахь орлого хамаарна", 11.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 26.1.1-д "энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан орлогын дүнд 23.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан хувь хүний орлогын албан татварыг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

3.9.2 Авлагын талаар

• Тайлант онд авлагыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.3 Бараа материалын талаар

• Жилийн эцсийн тооллогын комисс 233.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоог бодож, үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.4 Үндсэн хөрөнгийн талаар

• Улсын Дээд шүүх нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох зөвшөөрөлгүй 15.6 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авсан.



Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 07 дугаар тогтоолоор актлагдсан 10 нэр төрлийн 7.7 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг тайлант онд данс бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дээрх тогтоолын "хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэл тайланд тусгах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 07 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, нийт 7.7 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн хөдлөлийг бүртгэл тайландаа тусгах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.5 Зардлын талаар

- Тайлант онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гадны байгууллагын хүмүүсийг шагнаж урамшуулахад зориулж нийт 4.5 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан төсөв захирагчийн хүлээх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- 2017 онд "Ард даатгал" ХХК-тай гэрээ байгуулж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчдийн амь нас, эрүүл мэндийг даатгуулахдаа 1 шүүгчийн даатгалын зардал 1.5 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн 1.5 сая төгрөгийн даатгалын мөнгийг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

3.9.6 Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар

- Байгууллагын бэлэн мөнгөний кассын тайланг сар бүр гаргаж ирсэн боловч тайланг гаргасан эд хариуцагч болон нягтлан бодогч нар тайланд гарын үсэг зураагүй, шалгаж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.



• Урсгал зардлын хэмнэлтээс төсөвт буцаан төвлөрүүлсэн 687.6 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасах тохируулгыг хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 3.1-д "...улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тайлант онд авсан санүүжилтийн орлогоос төвлөрүүлсэн мөнгөн дүнг хасах тохируулгыг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын явцад залруулав.

3.9.7 Дотоод аудитын талаар

Тус байгууллагын дотоод аудитын алба нь 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 чиглэлд хяналт хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөө батлуулсан бөгөөд биелэлтийг тулган шалгахад удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт болон төсөв, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хийгдэхээр батлагдсан ажлууд огт хийгдээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлээр хийгдэх ажил бүрэн хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.8 Шилэн дансны талаар

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээллээс 44.7 сая төгрөгийн дүн бүхий 5 ш зардлын гүйлгээг оруулаагүй, бүх зардлын гүйлгээний шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т "*Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар ... хавсаргасан байна*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


Улсын Дээд шүүх нь 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Хан-Уул дүүргийн нутагт орших Богдхан уулын дархан цаазат газрын хилийн зааг дотор Зайсангийн амны хязгаарлалтын бүсэд 0.6 га газрыг Сургалт мэдээллийн төвийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ашиглахаар 5 жилийн хугацаатай гэрчилгээ авсан байна.

2011 онд тус төвийг барих зураг төсвийг 36.9 сая төгрөгөөр хийлгэж, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Т.Эрдэнэчимэгтэй 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдөр "Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээ" байгуулж, дээрх төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар тайлагнаж ирсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв батлагдаагүйн улмаас тус газрыг ашиглаж эхлээгүй байна.

Дээрх газрын төлбөрт тайлант онд 7.9 сая төгрөг төлсөн бөгөөд газар ашиглах хугацаа нь дууссан, цаашид газар эзэмших эрх сунгагдах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улсын Дээд шүүхийн Сургалт мэдээллийн төвийг барих төсөв батлагдах эсэх нь тодорхойгүй байгаа асуудалд анхаарал хандуулбал зохилтой байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит хийж буцааг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хөрөнгөнд биет төсөв хөрөнгүүдээгүй тул 2017 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.



3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар нийт 1,058.5 сая төгрөгийн алдаа, 37.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 687.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4.9 сая төгрөгийг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 403.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар холбогдох албан тушаалтанд 10 зөвлөмж хүргүүлээ.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2015 оны 240 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,192.2 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 83.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.


Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4.9 сая төгрөгийн санхүүгийн, 687.6 сая төгрөгийн санхүүгийн бус, нийт 692.5 сая төгрөгийн аудитын үр өгөөжийн тооцооллыг /Маягт УАГ 1120/ хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Улсын Дээд шүүхийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



4.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

1. Тайлант онд Улсын Дээд шүүхийн нэр дээрх байгууллагын картын дансаар тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн тэтгэмжийн 118.1 сая, ажилчдад олгох цалингийн 19.0 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг дамжуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.5-д *"Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар захиалга хийхдээ ... төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн хязгаарыг дагаж мөрдөнө"* гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

- Мөнгө хөрөнгө дутагдах;
- Сангийн сайдын баталсан журам зөрчигдөх.

ҮАГ-ын ажиглалт:

2. Бэлэн мөнгөний үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулдаггүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана"*, 70.2.4-т *"мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал ... сар бүрийн 1-нээр"* гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

- Сангийн сайдын баталсан холбогдох журам зөрчигдөх;
- Санхүүгийн тайлангийн оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй.

ҮАГ-ын зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ҮАГ-ын зөвлөмж:

Бэлэн мөнгөний үлдэгдлийг сар бүр тоолж тооцоог бодож баталгаажуулж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4.2 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд авлагыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг мөрдөж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд:

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4.3 Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Улсын Дээд шүүхийн жилийн эцсийн тооллогын комисс нь 233.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоог бодож, үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Оршин байх - санхүүгийн тайлан дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

ҮАГ-ын зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4.4 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

1. Улсын Дээд шүүх нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох зөвшөөрөлгүй 15.6 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх.

ҮАГ-ын ажиглалт:

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 07 дугаар тогтоолоор актлагдсан 10 нэр төрлийн 7.7 сая төгрөгийн балансын дүн бүхий үндсэн хөрөнгийг тайлант онд данс бүртгэлээс хасаагүй нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дээрх тогтоолын "хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэл тайланд тусгах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

ҮАГ-ын зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ҮАГ-ын зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 07 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, нийт 7.7 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн хөдлөлийг бүртгэл тайландаа тусгах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.5 Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гадны байгууллагын хүмүүсийг шагнаж урамшуулахад зориулж нийт 4.5 сая төгрөг зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан төсөв захирагчийн хүлээх үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд:

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.6 Нягтлан бодох бүртгэл, тайлагналийн
талаар**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Байгууллагын бэлэн мөнгөний кассын тайланг сар бүр гаргаж ирсэн боловч тайланг гаргасан эд хариуцагч болон нягтлан бодогч нар тайланд гарын үсэг зураагүй, шалгаж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд:

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.7 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Тус байгууллагын дотоод аудитын алба нь тайлант онд 10 чиглэлд хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулснаас удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилт болон төсөв, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр хийгдэхээр батлагдсан ажлууд хийгдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлээр хийгдэх ажил бүрэн хийгдээгүй байна.

Эрсдэлүүд:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж:

Дотоод аудитын үйл ажиллагааг Засгийн газрын 311 дүгээр тогтоолын холбогдох заалтуудтай нийцүүлэн сайжруулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.8 Шилэн дансны талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээллээс 44.7 сая төгрөгийн дүн бүхий 5 ш зардлын гүйлгээг оруулаагүй, бүх зардлын гүйлгээний шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т *"Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар ... хавсаргасан байна"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд:

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	223,431.01	275,703.87
31	Мөнгөн хөрөнгө	150.20	-
33	Авлага	-	4,950.32
34	Урьдчилгаа	36,965.60	36,965.60
35	Бараа материал	186,315.21	233,787.95
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	810,616.45	655,493.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	810,616.45	655,493.46
392	Биет хөрөнгө	798,181.74	646,938.24
393	Биет бус хөрөнгө	12,434.71	8,555.21
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,034,047.46	931,197.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	161.73	-
41	Богино хугацаат өр төлбөр	161.73	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,033,885.72	931,197.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,033,885.72	931,197.33
511	Засгийн газрын оруулсан капитал	1,148,315.01	1,148,315.01
512	Хуримтлагдсан үр дүн	(252,958.10)	(355,646.50)
51210	Өмнөх үеийн үр дүн	(76,567.73)	(252,958.10)
51220	Тайлант үеийн үр дүн	(176,390.37)	(102,688.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	138,528.82	138,528.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,034,047.46	931,197.33

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,417,435.50	4,089,515.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,945.20	6,377.65
120	Нийтлэг татварын бус орлого	4,945.20	6,377.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,412,490.30	4,083,137.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,593,825.87	4,192,203.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,593,825.87	4,192,203.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,286,583.10	3,489,292.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,340,285.96	2,416,042.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,095.58	262,474.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,797.55	62,071.00
2104	Хангамж, бараа материалын зардал	113,966.26	86,541.28
2105	Нормативт зардал	100.00	240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,729.58	90,644.67
2107	Томилолт, зочны зардал	45,021.60	83,424.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,319.37	75,251.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	376,267.21	412,602.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	307,242.77	702,910.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(176,390.37)	(102,688.40)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН	(176,390.37)	(102,688.40)



5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
3	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,143,622.61	138,528.82	(76,567.73)	1,205,583.70
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,622.61	138,528.82	(76,567.73)	1,205,583.70
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	4,692.39	0.00	0.00	4,692.39
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(176,390.37)	(176,390.37)
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,148,315.01	138,528.82	(252,958.10)	1,033,885.72
11	2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,148,315.01	138,528.82	(252,958.10)	1,033,885.72
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,148,315.01	138,528.82	(252,958.10)	1,033,885.72
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
18	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(102,688.40)	(102,688.40)
19	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,148,315.01	138,528.82	(355,646.50)	931,197.33

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,431,161.81	4,089,515.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,671.51	6,377.65
120	Нийтлэг татварын бус орлого	18,671.51	6,377.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,412,490.30	4,083,137.60
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,383,709.91	4,031,910.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,383,709.91	4,031,910.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,062,252.83	3,307,945.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,342,494.95	2,375,005.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,041.00	284,619.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,797.55	62,071.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,455.08	141,253.00
2105	Нормативт зардал	-	1,629.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,753.60	131,548.12
2107	Томилолт, зочны зардал	45,021.60	84,476.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,605.39	84,948.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,083.67	142,394.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,457.08	723,964.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	47,451.90	57,604.68
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	47,301.70	57,754.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,301.70	57,754.88
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,301.70)	(57,754.88)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	150.20	(150.20)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	150.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	150.20	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,083,137.60	3,395,579.16	(687,558.44)	83.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,083,137.60	3,395,579.16	(687,558.44)	83.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,573,597.10	3,359,700.77	(213,896.33)	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,587,446.10	2,375,005.12	(212,440.98)	91.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,619.10	284,619.10	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,436.60	62,071.00	(365.60)	99.4
2104	Хангамж, бараа материалын зардал	136,756.40	136,052.90	(703.50)	99.5
2105	Нормативт зардал	1,656.90	1,629.70	(27.20)	98.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	188,674.60	188,503.10	(171.50)	99.9
2107	Томилолт, зочны зардал	84,476.60	84,476.60	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,088.40	84,948.80	(139.60)	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	142,442.40	142,394.46	(47.95)	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	509,540.50	35,878.39	(473,662.11)	7.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	509,540.50	35,878.39	(473,662.11)	7.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,083,137.60	3,395,579.16	(687,558.44)	83.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,083,137.60	3,395,579.16	(687,558.44)	83.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	150.20		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

